



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 5 сарын 31 өдөр

Дугаар А/25

Чингис хот

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчийн удирдлаган доор байгууллагын архивт нягтлан шалгалт хийх, хадгаламжийн нэгж үүсгэх, АЗДТГ-т ирсэн явсан бичгүүд бүртгэж, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож мэргэжлийн дадлагаа амжилттай хийж гүйцэтгэсэн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн компьютер операторч, албан хэргийн ажилтны мэргэжлийн ангийн сурагч А.Нарантунгалаг, н.Тэмүгин нарыг урамшуулсугай.

Хоёр. Сурагчдын шагналыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх шагналд зарцуулагдах 76000 /далан зургаан мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын сангаас гаргахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2017 оны 5 дугаар сарын 31-ны
өдрийн А/25 дугаар тушаалын хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Мөнгөн дүн	Гарын үсэг
1	Мөнгөн дүн	1 хүн	20.000	
2	Мөнгөн дүн	1 хүн	20.000	
3	Өргөмжлөл	2 хүн	10.000	
4	Цэцэг	2 хүн	26.000	
Нийт			76.000	